

**ДАЛАЙН ЗАХИРГААНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025.02.15

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Зам, тээврийн яамны харьяа байгууллага болох Далайн захиргааны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Гурав. Үнэлэлт.

Далайн захиргааны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар **82.1** хувьтай байна.

3.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц

Далайн захиргааны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 48 ажил, үйлчилгээний жилийн эцсийн хэрэгжилтийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс (хувиар)						Хугацаа болоогүй
		100	90	70	50	30	0	
48	82.1	37	1	-	-	5	5	-

3.2 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

Эрхзүйн актын нэр	Нийт арга хэмжээ	Хэрэгжилт /хувиар/	Үүнээс хэрэгжилтийн хувиар				Хугацаа болоогүй
			100	70	30	0	
Ерөнхий сайдын захирамж	1	30.0	-	-	1	-	-
Дүн	1	30.0	-	-	1	-	-

3.3 Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс (хувиар)				Хугацаа болоогүй
		100	70	30	0	

9	74.4	5	2	1	1	-
---	------	---	---	---	---	---

3.4 Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

№	Мэдээллийн агуулга	Байршуулбал зохих мэдээллийн төрөл	Хэрэгжилтийн дундаж хувь	Тайлант хугацаанд байршуулсан (хувиар)	Хугацаа хоцроож байршуулсан (хувиар)					Хугацаа болоогүй (төрлийн тоо)	Оруулах мэдээлэлгүй
					100	90	70	50	30		
1	Төсөв, гүйцэтгэл	14	53.7	3	-	1	-	2	-	-	8
2	Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	6	70.0	2	-	-	1	1	-	-	2
3	Бусад	8	100.0	4	-	-	-	-	-	-	4
Дүн		28	79.2	9	-	1	1	3	-	-	14

3.5 Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлтийн төрөл	Хэрэгжил -тийн дундаж хувь	Хэрэгжүүлэх үзүүлэлтийн тоо	Үүнээс /хувиар/					
				100	70	30	0	Хугацаа болоогүй	Хамааралгүй
1	Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	62.5	10	3	2	2	1	-	2
2	Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал	50.0	6	3	-	-	3	-	-
3	Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	90.9	15	10	-	-	1	2	2
4	Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	100.0	2	1	-	-	-	-	1

5	Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	100.0	13	2	-	-	-	2	9
Дүн		75.0	46	19	2	2	5	4	14

Дөрөв. Дүгнэлт:

I. Төлөвлөлтийн байдал:

1. Далайн захиргааны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний зорилтот түвшнийг тодорхой төлөвлөлгүй ерөнхий байдлаар төлөвлөснөөс гадна хугацааг улирал бүрээр тодорхойлоогүй байна. Тухайлбал: 3.1, 4.6, 4.7, 5.3, 5.6, 6.2 гэх мэт.

2. Тус байгууллага нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө бэлтгэл ажил ханган ажиллах, судалгааг эхлүүлэх, гэрээний хэрэгжилтийг болон даатгалын компаниудыг шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан байна гэх зэргээр зорилтот түвшнийг тодорхой, хэмжигдэхүйцээр төлөвлөлгүй ерөнхий байдлаар төлөвлөсөн цөөнгүй арга хэмжээ байна. Тухайлбал: 2.6, 2.9, 4.6, 4.7.

II. Хэрэгжилтийн байдал:

1. Далайн захиргаа нь 2024 онд үйл ажиллагаандаа нийт 132 арга хэмжээ хэрэгжүүлж ажилласнаас 100 хувийн үнэлгээтэй 70, 90 хувийн хэрэгжилттэй 1, 70 хувийн хэрэгжилттэй 5, 50 хувийн хэрэгжилттэй 1, 30 хувийн хэрэгжилттэй 12, тасарсан буюу хэрэгжүүлээгүй 11, хугацаа болоогүй 4, хамааралгүй 14, оруулах мэдээлэлгүй 14 арга хэмжээ байгаа бөгөөд хэрэгжилт дунджаар **78.5** хувьтай байна.

2. 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 268,231.28 MTS буюу 295,647.61 тонн ачаа 2024 онд нийт 3,320,420.54 MTS буюу 3,660,140.11 тонн ачаа Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцоор тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 3,364,492.5 тонн ачааг илүү тээвэрлэсэн байна.

3. Замын-Үүд, Бичигт байршлуудад хуурай боомт байгуулахад хөрөнгө оруулалт татах, усан замын боомт байгуулах боломжийн талаар, Төв аймгийн Хөшигийн хөндий дэх “Чингис Хаан Олон Улсын нисэх буудал”-ыг түшиглэн олон улсын чанартай хуурай боомт байгуулах олон төрөлт тээврийн холболт, замын хөдөлгөөний эрчимжлийн судалгаа, далайн шинэ боомт ашиглах, хуурай боомтыг түшиглэн олон улсын цахим худалдааны нэгдсэн сүлжээ байгуулах тухай зэрэг судалгааны ажлуудыг жил тутам бүрэн хэрэгжүүлж ажилладаг.

4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 3.1. “Далайг хог хаягдал болон бусад зүйлсээр бохирдуулахаас урьдчилан сэргийлэх тухай” 1972 оны конвенцын 1996 оны Протоколд нэгдэн ороход дэмжлэг үзүүлэн ажиллах, 3.2. “Олон улсын далайн тээврийн хөдөлгөөнийг хөнгөвчлөх тухай” 1965 оны Конвенц, түүний нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн ороход дэмжлэг үзүүлэн ажиллах, 4.7. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдэж байгаа хөлөг онгоцыг Монголын даатгалын компанид даатгуулах боломжийг олгох, 5.5. Цахимжуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлж ажиллах, 6.6. Ази, Номхон далайн бүс нутгийн далайн аюулгүй байдлын агентлагуудын удирдлагын зөвлөлийн 24 дүгээр зөвлөгөөнд оролцох гэсэн ажлыг 2 улирал дараалан хангалтгүй хэрэгжүүлсэн.

5. Жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ирүүлэхдээ зарим арга хэмжээний хэрэгжилтийг үнэн зөв ирүүлээгүй, хэрэгжүүлэн ажилласан гэх ерөнхий байдлаар албан бичгийн огноо болон дугаарыг бичихгүй орхигдуулан тайлагнаж байгаа дутагдлууд байна.

6. Хариуцан хэрэгжүүлж байгаа арга хэмжээний биелэлтийг тайлант хугацаанд хамааруулж тухай бүр шинэчлээгүйгээс гадна цаг хугацааны хувьд ач холбогдлоо алдсан, үр дүнг оновчтойгоор тодорхойлоогүй ажлын явцыг бичиж тайлагнасан хэвээр байна.

7. Далайн захиргааны 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн зөвлөмжөөс дараах зөвлөмжүүд бүрэн хэрэгжээгүй хэвээр байна. Үүнд:

- Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан төсөв, санхүүжилт шаардлагагүй ажлыг бүрэн хэрэгжүүлэхээс гадна, төлөвлөгөө болон түүний хэрэгжилтийг хавсралтаар гарган ирүүлж хэвших;
- Хариуцан хэрэгжүүлж байгаа арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа дэвшүүлсэн зорилтын хүрээнд зохион байгуулсан гол ажлаа хүрсэн үр дүн, зорилтот түвшинтэй нь уялдуулж, хоёр мянган тэмдэгтэд багтаан ажлын үйл, явц тоочилгүй, огноог тодорхой дурдан, зөв бичгийн дүрмийн алдаагүй тайлагнаж хэвших;
- Тус байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтан байгууллагынхаа гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд улирал тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг албан бичгээр ирүүлэх;
- Шилэн дансанд байршуулдаг мэдээллийг тогтоосон хугацаанд нь тухай бүр байршуулж хуулийн хэрэгжилтийг хангах;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, байгууллагын цахим сайтад ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн мэдээллийг цаг тухайд нь байршуулан хөгжүүлэлт хийхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;
- Цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган, төлөвлөлтийг зөв тодорхойлж, ажлаа бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна.

Тав. Санал, зөвлөмж

1. Дорноговь аймгийн Замын-Үүд суман дахь “Бүс нутгийн логистикийн төв”-ийг түшиглэн олон улсын чанартай хуурай боомт байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын асуудлыг судлах, санал боловсруулах, гадаад улс, олон улсын байгууллагын дэмжлэг авч, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангах ажлыг бүрэн хэрэгжүүлэх;

2. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдэж байгаа хөлөг онгоцыг Монголын даатгалын компанид даатгуулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжилтийг эрчимжүүлэх;

3. Далайн салбарын байгууллагуудтай шинээр хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгүүдийг байгуулахаас гадна байгуулагдсан санамж бичгийн хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр тодорхой ажлууд зохион байгуулах;

4. Эрх бүхий байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулж Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийг өргөжүүлэн, хөлөг онгоц бүртгэлийн зуучлагч, агентын сонгон шалгаруулах ажлыг түргэвчлэх;

5. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын шалгалтын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллах, санхүүгийн сахилга бат, хяналтыг сайжруулах;

6. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан хүний нөөцийн болон нийгмийн баталгааны хөтөлбөр, тэдгээрийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, цахимжуулах үйл ажиллагааны

төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлж ажиллах зэрэг төсөв санхүүжилт шаардахгүйгээр хэрэгжүүлэх боломжтой ажлыг бүрэн хэрэгжүүлж ажиллах;

7. Хариуцан хэрэгжүүлж байгаа арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа дэвшүүлсэн зорилтын хүрээнд зохион байгуулсан гол ажлаа хүрсэн үр дүн, зорилтот түвшин, хэрэгжүүлэх хугацаатай нь уялдуулж, үнэн зөв, монгол хэлний зөв бичгийн дүрмийн алдаагүй, хоёр мянган тэмдэгтэд багтаан тайлагнаж хэвших;

8. Шилэн дансанд байршуулдаг мэдээллийг тогтоосон хугацаанд нь тухай бүр байршуулж шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг тогтмол хүргэх;

9. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлж, байгууллагын цахим сайтад ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн мэдээллийг бүрэн байршуулж, хөгжүүлэлт хийн, хоёр улирал дараалан хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

10. Тус байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтан байгууллагынхаа гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд улирал тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг албан бичгээр ирүүлэх;

11. Цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган, төлөвлөлтийг зөв тодорхойлж, ажлаа бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР